

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын  
2024 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн  
01/195-О тоот албан бичгийн хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД  
СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДААС АВЧ ХЭРЭГЖҮҮДСЭН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛАН**

Салбарын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02-00/12 дугаартай “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэгцээ, шаардлагыг хангуулах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамж, Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. Тус газар нь 2 нэгж, 12 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулахаас 11 албан хаагч ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд заасан “...25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна.”-аар хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаагүй болно.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд соёлын байгууллагуудад очиж төрийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн гадна орчинд орц, гарцыг бий болгож, ариун цэврийн өрөөг стандартад нийцсэн хүрээмжтэй болгосон байна. Тухайлбал:

2.1.Залуучууд театр: Нийтийн /эр, эм/ ариун цэврийн өрөөнүүдийг засварлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тулц болон бариулуудыг худалдан авч суурилуулсан.

2.2.Музей: Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан “Найрамдал”-ын танхимд Дархан хотын бүтээн байгуулалтын брайл үсгээр тайлбар бэлтгэж байршуулсан.

2.3.Төв номын сан: Дархан сумын Засаг дарга, ИТХ-ын зөвлөлд Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг ажлын хүрээнд 60.0 сая төгрөгийн өртөгтэй “Харааны бэрхшээлтэй уншигчдад номын сангийн үйлчилгээ үзүүлэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь” төслийг танилцуулж батлуулсан. Төсөл хэрэгжснээр аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 4578 буюу 4.7% нь соёлын үйлчилгээг авах боломжоор хангагдах болно. Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан хальтирдаггүй наалтуудыг шат болон шулуун зам дээр нааж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан. Шинээр баригдаж буй Музей, номын сангийн

цогцолбор барилгын зураг төсөв хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн танхимыг оруулж өгсөн.

2.4. Хүүхдийн номын ордон: Гадна орчинд орц, гарцыг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох, гарах боломжийг хангасан налуу замтай болгосон.

2.5. Шарын гол сумын Соёлын төв: Гадна орчинд орц, гарцыг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох, гарах боломжийг хангасан налуу замтай болгосон.

2.6. Орхон сумын Соёлын төв: Гадна орчинд орц, гарцыг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох, гарах боломжийг хангасан налуу замтай болгосон. 2024 оны сүүлийн хагас жилд багтаан батлагдсан төсвийн хүрээнд аврах гарцын хаалга, нийтийн ариун цэврийн өрөөг засварлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх стандартад нийцсэн зам, гарц, тулц болон бариулуудыг бий болгоно.

2.7. Хонгор сумын Соёлын төв: Гадна орчинд орц, гарцыг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох, гарах боломжийг хангасан налуу замтай болгосон.

НЭГТГЭН ТАЙЛАГНАСАН:  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



С.ТУЯА